



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/393

Чингис хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зөвшөөрлийн хугацаа 2020 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр дуусаж байгаа тул боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан 2029 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл сунгасугай.

2. Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу чанар, хүртээмжтэй зохион байгуулахыг тус сургуулийн захирал /Д.Солонго/-д, удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201010432